

Төсвийн хуваарь 2013 он

{ppgallery}

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН САЛБАР
ХОРООНЫ ТОГТООЛ

2015 оны 09 сарын 17 өдөр

Дугаар 9

Улаанбаатар

Г Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэсгийн хорооны бүрэлдэхүүнийг томилох, буцаах тухай 7

Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн дугаар тушаалын 2 дугаар хавсралтын 1.6 дахь хэсэг, Эмнэлгийн мэргэжилтний зүйн салбар хорооны 2015 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн хурлын тэмдэглэл тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа зарим эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэсгийн хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар баталж, 2015 оны 09 дүгээр сарын 14-өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай томилон ажиллуулсугай.

2. Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 92 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 3.5.1-д заасан шаардлага хангаагүй Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Налайх, Багануур, Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төвүүд, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Наркологи, Энэрэл эмнэлэг, ШЭНТ, Хүрээ, Амгалан амаржих газруудын дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэсгийн хорооны бүрэлдэхүүнийг баталгаажуулахаас татгалзаж, буцаасугай.

3. Буцаагдсан эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэсгийн хорооны бүрэлдэхүүнийг шинэчилж, 2015 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн дотор шаардлага хангаж ирүүлэхийг эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэсгийн хорооны нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.

4. Хэсгийн хорооны үйл ажиллагааны тайланг Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороонд хагас жил тутам тайлагнаж байхыг хэсгийн хорооны дарга нарт даалгасугай.

5. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

ДАРГА

М.ЦЭРЭНБАТ

{/ppgallery}